

СЭТГҮҮЛЧИЙН ЁС ЗҮЙН “ЗАЛЬ МЭХ, ТӨӨРӨГДҮҮЛЭЛТ, ХУДАЛ ТАШАА  
АРГА ХЭРЭГЛЭХГҮЙ” ҮНДСЭН ЗАРЧМЫГ ТАЙЛБАРЛАХ НЬ

Д.Идэржаргал\*

\*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, магистр (МА)

**Түлхүүр үг:** сэтгүүлчийн ёс зүй, сэтгүүлчийн ёс зүйн үндсэн зарчмууд, худал хуурмаг аргыг ашиглахгүй байх зарчим

Олон улсад сэтгүүлчийн ёс зүйн асуудлыг авч үздэг мэргэжлийн холбоод сэтгүүлчийн ёс зүйн зарчмын агуулгыг салбарын хөгжлийг дагуу нэмж баяжуулж байдаг. Тэдгээр олон кодод<sup>1</sup> үргэлж давхцаж байдаг сэтгүүлчийн ёс зүйн үндсэн зургаан зарчим бий. Эдгээр нь:

1. Үнэнийг эрэлхийлж үнэнийг мэдээлнэ
2. Хор уршгийг бууруулна
3. Заль мэх, төөрөгдүүлэлт, худал ташаа арга ашиглахгүй
4. Ашиг сонирхлын зөрчилгүй ажиллана
5. Хүнлэг байна
6. Ялгаат байдлыг хүлээн зөвшөөрнө (сүүлд нэмэгдсэн) болно.

Сэтгүүлчийн ёс зүйн үндсэн зарчмуудаас “Заль мэх, төөрөгдүүлэлт, худал ташаа арга ашиглахгүй байх” зарчмыг дэлгэрүүлж авч үзье. Сэтгүүл зүйн мөн чанар нь үнэн учраас сэтгүүлч хүн худал хуурмаг аргаар ажиллана гэдэг ёс зүйн ноцтой асуудалд тооцогддог.

Мэдээллийн эрин зууны энэ нийгэм итгэлцлийн түвшин бууу хүмүү-

сийн солилцож, хуваалцаж буй мэдээлэл хэр үнэн байгаа эсэхээс шууд хамаарна<sup>2</sup> хэмээн дэлхийн томоохон асуудлуудыг шийдвэрлэхэд өгөгдөл, судалгаагаар хувь нэмрээ оруулах зорилготой олон улсын топ сургуулиудын судлаачдын платформ “Our world in data”-гийн судалгаанд онцолжээ. Хэрвээ энэ итгэлцэл байхгүй бол хүмүүс хоорондын харилцаа бөглөрч, нийгмийн үүрэг гажих болно гэж үзжээ. Харин сэтгүүлчид “худал хуурмаг аргаар ажиллахгүй байх зарчим”-аа баримтлах нь бидний нийгмийн сэтгүүл зүйд итгэх итгэлцлийн түвшинд шууд нөлөөтэй гэж үзэж болно. Эсрэгээрээ энэ зарчмыг үл баримталбаас олон нийтийн сэтгүүл зүйд итгэх итгэл үлэмж буурна.

Үнэний үнэ цэн талаас бодож үзвэл хамгийн түрүүнд мэдээлэл цуглуулах, нийтлэхдээ хэн нэгнийг хуурч мэхлэх нь сэтгүүлчийн хувьд хэр ёс зүйтэй вэ? гэж асуух нь зүйн хэрэг. Сэтгүүлчид бүх нийтээр санал нийлж хариулдаггүй. Зарим нь үнэнийг хэлэх зорилготой мэргэжилтнүүд хуурч мэхлэх нь хүлээн зөвшөөрч боломжгүй үздэг. Харин зарим нь хуурч мэхлэхээс зайлсхийх хэрэгтэй ч ховор тохиолдолд буюу тухайн мэдээлэл нь нийгмийн өндөр ач холбогдолтой тохиолдолд ямар нэг аргаар мэдээлэл олохыг

хүлээн зөвшөөрөх ёстой гэдэг. Ялангуяа эрэн сурвалжлах сэтгүүл зүйд энэ асуудал үргэлж хөндөгддөг. Харин зарим нь хуурч мэхлэх хэлбэрүүд нь хоорондоо ялгаатай (бүр мөсөн худал хэлэх, бүх үнэнийг илчлэхгүй байхын ялгаа г.м) буюу олон нийтийн газар нууц камер ашиглах, хэн нэгэн болж жүжиглэж буй этгээдийг нотлохоор нууц камер ашиглах хоёр ялгаатай гэж тайлбарладаг.

Заримдаа хуурч мэхлэх нь үнэнийг олох арга байж болох ч сэтгүүл зүйд итгэх итгэл болон хуурч мэхлэгдсэн хүндээ ихээхэн хохирол авчирч болно. Этисист Сиссела Бок “Худал хуурмаг: Албаны болон амины амьдралдаа ёс суртахуунтай сонголт хийх нь” (Lying: Moral Choice in Public and Private Life) номдоо худал хэлэх нь хуурахын нэг хэлбэр хэмээгээд “Санаатайгаар хуурч мэхэлсэн мессеж бүрийг би худал хуурмаг гэж тодорхойлно”<sup>3</sup> хэмээсэн байна. Бок хууран мэхлэлтийг өргөн утгаар авч үзсэн. “Бид хэн нэгнийг санаатайгаар хуурахдаа өөрсдийнхөө итгэдэггүй зүйлд тэднийг итгүүлэхийн тулд тэднийг төөрөгдүүлэх зорилгоор харилцдаг”<sup>4</sup> гэжээ. Энэ харилцаанд гарын хөдөлгөөн, биеийн хэлэмж, зүсээ хувиргах, үйлдэл ба эс үйлдэл, тухайлбал дуугүй байх ч орно гэсэн байна.

**С**этгүүл зүйд худал хуурмаг арга ашиглах нь худал хэлэх, төөрөгдүүлэх, гуйвуулах болон шулуун шударгаар ажиллаагүй гэх мэт олон хэлбэртэй байж болно. Эдгээр бүх үйлдлүүд нь хэн нэгнийг үнэн биш зүйлд итгэхэд хүргэдэг. Тэгвэл бид хэрхэн худал хуурмаг аргаар ажиллахгүй байх вэ, ямар үед энэ хил хязгаарыг давах ёстой вэ?

Худал хэлсэн эсвэл хуурч мэхэлснийг зөвтгөхийн тулд дараах 5 шалгуурыг давах ёстой. Ингэхдээ ямар

түвшинд хуурч мэхэлснийг тодорхойлноор сэтгүүлчийг зөвтгөж болох эсэх нь шалтгаална гэж “The Poynter Institute”-ийн ёс зүйн семинарт оролцсон сэтгүүлчид үзсэн байна. Тэд “Сэтгүүлчийн заль мэх, төөрөгдүүлэлт, худал ташаа арга ашиглахыг хэзээ зөвтгөж болох вэ?” гэдгийг хэлэлцээд дараах шалгууруудыг<sup>5</sup> гаргажээ.

1. Мэдээллийн эрэлт хэрэгцээ маш чухал үед. Ийм мэдээлэлд олон нийтийн ашиг сонирхолд амин чухал буюу өндөр түвшний “системийн алдаа”-г илчлэх эсвэл олон нийтийг ноцтой хор уршигт өртөхөөс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой мэдээ мэдээлэл багтана.
2. Энэ мэдээллийг олж авах бусад арга шавхагдсан үед.
3. Хуурч мэхэлсэн хэлбэрээ бүхэлд нь нээлттэйгээр мэдээлж, олон нийтийн эрх ашигтай хэрхэн холбогдож буйг тайлбарласан тохиолдолд.
4. Хуурамч аргаар олж авсан мэдээллийг илчилснээр сэргийлэх хор уршиг нь хуурамч аргаар мэдээлэл олж авснаар гарах хор уршгаас харьцангуй илүү их байх үед.
5. Холбогдсон сэтгүүлчид ёс зүйн шийдвэр гаргахдаа албан ёсны, хамтын, хүлээн зөвшөөрч болох хэлэлцүүлгийг зохион байгуулж, үүндээ дараах асуудлуудыг хэлэлцсэн тохиолдолд.
  - Мэхлэгдсэн хүмүүст учрах урт болон богино хугацааны үр нөлөө
  - Сэтгүүлчид, сэтгүүл зүйд итгэх итгэлд нөлөөлөх байдал
  - Сэтгүүлчдийн үйлдэлд үзүүлэх мотивацийн үр нөлөө
  - Редакцын үүрэгт хуурч мэхлэх үйлдлийг авч үзсэн байдал
  - Энэхүү үйлдлийн талаарх хуулийн ойлголт

- Өөрсдийн үйлдэл болон үүнийг хийж буй учир шалтгааны өрсөлдөх байдал багтана.

Заль мэх, төөрөгдүүлэлт, худал ташаа аргыг ашиглахгүй байх зарчмын сонгодог кэйсүүдэд эдгээр шалгуурыг хэрхэн хангасныг танилцуулъя. Эхний кэйс нь “ABC News ба Хоолны арслан”. Энэхүү хэрэг 29 жилийн өмнө хэвлэгдсэнээсээ хойш хууран мэхлэлтийн сонгодог кэйс болжээ. “ABC News”-ийн сэтгүүлчид олон жилийн турш олон тохиолдолд нууц камер ашигласан бөгөөд олж авсан мэдээллээ сүлжээнийхээ “Prime Time Live” нэвтрүүлгээр цацаж байжээ. Тэдгээр түүхүүд асрах төв, өдөр өнжүүлэх төв болон ахмадын эмнэлгүүдийн хууль бус, аюултай нөхцөл байдлыг илчилсэн юм. Бусад тохиолдолд сэтгүүлчид нууц камерыг татварын залилан, газрын эзэд болон үл хөдлөх хөрөнгийн агентуудын арьс өнгөөр ялгаварлаж буй байдлыг илчлэхэд ашиглажээ.

Өнөөг хүртэл “Prime Time Live”-ийн нэг ч дугаар тухайн үеийн “Хоолны арслан” сүлжээ супермаркетын тухай сурвалжилга шиг олон нийтийн анхаарлыг үлэмж татаж, сэтгүүлчийн мөн чанарыг эрэлхийлэхэд хүргээгүй хэмээн мэргэжлийн ёс зүй судлаачид тэмдэглэжээ<sup>6</sup>.

“Хоолны арслан”-д эрүүл ахуйн шаардлагыг зөрчиж, бохир аргаар хүнс хоол савлаж буйг эрэн сурвалжлахын тулд “ABC”-гийн хоёр продюсер 1992 оны хавар Каролин муж дахь олон супермаркетэд богино хугацаанд ажиллажээ. Продюсерууд ажилд орох өргөдөлд өөрсдийгөө хуурамчаар танилцуулж, ажиллахаар болсон тохиолдолд парик зүүж эсвэл хувцсандаа камераа нууж, сурвалжилгадаа зориулан аудио, видео бичлэг хийж авдаг байв. “Prime Time Live”-ийн энэ дугаар 1992 оны 11

дүгээр сард цацагджээ. Нууц камерын бичлэг хулгана идсэн бяслаг, муудсан мах, цайруулагчаар угаасан тахианы мах зэргийг дахин савлаж, шинэ он сар наан худалдаалж буйг илчилжээ. Ярилцах үеэр “Хоолны арслан”-гийн ажилчид ийм үүрэг авч байсан тухайгаа өгүүлж, үүгээр ч зогсохгүй тэнд ажиллаад гарсан олон хүн бохир нууцыг хадгалах амлалтад гарын үсэг зурж байснаа ярьжээ.

“Хоолны арслан” энэхүү нэвтрүүлгээс болж их хэмжээний буюу худалдаанаас 1.7 тэрбум, хувьцаанаас 2.5 тэрбум ам.долларын хор хохирол амссанаа мэдэгджээ. Сурвалжилгын үнэн нь “стандарт” болсон “Хоолны арслан” шүүхэд гүжирдэж гүтгэсэн хэргээр нэхэмжлэл гаргаагүй. Харин оронд нь “ABC”-гийн сэтгүүлчид манай дэлгүүрүүдэд томилогдсон ажлаа хийхийн оронд сэтгүүлчийн үүргээ гүйцэтгэхэд ажлын цагаа зарцуулж луйвардсан, хувийн өмчид зүй бусаар халдсан гэж гомдол гаргажээ. Мөн “Хоолны арслан”-гийн хуульчид сэтгүүлчдийг сурвалжилгадаа ч зарим алдааг гаргасан гэж мэдэгдээд, тэд сурвалжилгаа илчилсэн муу нөхцөл байдлын заримыг бий болгоход өөрсдөө нөлөөлсөн гэсэн байна. Үүгээр ч зогсохгүй менежментэд сэтгэл хангалуун бус байгаа гэж ярьсан сүлжээ супермаркетын холбооны дэмжигчид гэгдэх хүмүүс нь холбооны бус хүмүүс байсан учир нэр төрийг унагах мэдэгдэл хийсэн гэж буруутгажээ.

**Х**уурамч аргаар үнэнийг олж авсан сэтгүүлчид шударга ажилласан уу? “Prime Time Live” хуурч мэхэлсэн нь сэтгүүлчид сүлжээ супермаркетэд орохын тулд байсан учир зөвтгөгдөнө гэх нь ойлгомжтой. “ABC News” “Хоолны арслан”-гийн өмнөх болон өнөөгийн ажилчдын

ярилцлага зэргийг багтаасан, тус байгууллага эрүүл ахуй, аюулгүй байдал, ажлын стандартыг зөрчсөнийг нотлох санаанд багтамгүй баримтуудыг олсон. Гэвч “ABC News”-т дээрх үйлдлүүдийг үнэн болохыг батлах анхдагч эх сурвалжийн нотолгоо хэрэг болсон. Сурвалжилга дайрсан өнгө аястай байсан хэдий ч бусад хүмүүсийн хүнснээс хордох хамаарлыг буруулсан хэмээснээр шударга ёсонд нийцсэн болно.

Түүнчлэн “ABC” энэ тохиолдолд сурвалжилгын бусад аргууд ижил түвшний ач холбогдол бүхий мэдээлэл, баримтыг олох боломжгүйг дурдаж болно. Мэдээж “ABC” мах, загасан бүтээгдэхүүнийг худалдан авч шалгах боломжтой ч (буруу аргад тооцогдохгүй) энэ нь супермаркетын хууль бус үйлдлийн цаадах учир шалтгаан, хэмжээ хязгаарыг илчилж чадахгүй. Энэ мэтээр тэднийг зөвтгөж болно.

Гэвч нэг ноцтой асуулт гарч ирсэн. Хэрвээ “ABC News” хуурч мэхлэх аргаа зөвтгөхдөө олон нийтийн эрүүл мэндэд ноцтойгоор заналхийлсэн гэж тайлбарлаж байгаа юм бол яагаад ийм ноцтой асуудлыг анхааруулах товчийг дарахдаа тэгж их удсан юм бэ? Сурвалжилгыг яагаад бүхэл бүтэн зургаан сар хүлээж байж “Prime Time Live”-аар гаргав?

Нууц камер ашиглах, цаашлаад хуурамч аргаар мэдээлэл олж авахыг

зарим тохиолдолд зөвтгөж болох ч эдгээр багаж нь хурц ирмэгтэйг мартаж болохгүй. Тэд гэмгүй хүмүүст хор хохирол учруулж, сэтгүүлчийн шударга байх зуршлыг эвдэж ч болно. Ийм аргыг хэтрүүлэн ашиглавал үр ашгаа алдаж эхэлдэг.

Хуурч мэхлэх аргаар мэдээлэл олж авахаар шийдсэн ОНМХ бүтээлээ мэргэжлийн өндөр түвшний стандартад хүрч буй эсэхийг анхаарах үүрэгтэй. “Хоолны арслан”-гийн талаарх “ABC”-гийн сурвалжилга мэргэжлийн ёс зүйн өндөр стандартад нийцсэн эсэхийг шүүх шийдвэрлээгүй. Олон нийт болон бусад мэргэжилтнүүд үүнийг хэлэлцэх

биз. Хуурч мэхлэх аргаар хууль бус үйл ажиллагааг илрүүлж, олны анхаарлын төвд аваачсан энэ сурвалжилгын үр нөлөө бусдаас харьцуулшгүй өндөр байсан ч олон нийт сэтгүүл зүйд итгэсэн оргил үед анхааруулах товчийг хагас жилийн дараа сунжруулж дарсан гэх шалтгаан нь сэтгүүлчдэд итгэх итгэлийг буруулсан ч байж болох юм.

Хоёр дахь кэйс бол “Оршуулгын товчооны эзний баг”. Персийн булангийн

дайны үед чөлөөт сэтгүүлч Жонатан Франклин оршуулгын товчооны эзний дүр эсгэн Доверийн Агаарын хүчний бааз дахь оршуулгын газарт нэвтэрчээ. Тэрээр цэргийнхэн дайны үеэр амь насаа алдсан хүмүүсийн тоог багасган мэдээлж байгаа эсэхийг мэдэхийг



**Нууц камер ашиглах, цаашлаад хуурамч аргаар мэдээлэл олж авахыг зарим тохиолдолд зөвтгөж болох ч эдгээр багаж нь хурц ирмэгтэйг мартаж болохгүй. Тэд гэмгүй хүмүүст хор хохирол учруулж, сэтгүүлчийн шударга байх зуршлыг эвдэж ч болно. Ийм аргыг хэтрүүлэн ашиглавал үр ашгаа алдаж эхэлдэг.**

**Хуурч мэхлэх аргаар мэдээлэл олж авахаар шийдсэн ОНМХ бүтээлээ мэргэжлийн өндөр түвшний стандартад хүрч буй эсэхийг анхаарах үүрэгтэй**



хүссэн юм. Түүний сэжиг үнэн байсныг олж мэджээ.

Панамыг булаан эзэлсний дараах дайны үхлийн тухай өмнөх сурвалжилгадаа үндэслэн Франклин, Пентагоныг амиа алдсан албан хаагчийн тоог бууруулж байна гэж сэжиглэв. Пентагон сэтгүүлчдийг Доверийн Агаарын хүчний баазад үхэгсдийг буулгах үеэр зураг дарах, бүр энэ үед тэнд байхыг хориглосон тул Франклины арга мухардаж, тэнд нэвтрүүлэх хамгаалалтыг давахын тулд баг “нөмрөхөөр” шийдсэн байна.

Хэрвээ сэтгүүлч мэдээлэл цуглуулахдаа хуурч мэхэлсэн бол энэ тухайгаа нийтлэлдээ бичих ёстой. Сэтгүүлч булангаас явуулсан цогцсуудыг оршуулах зөвшөөрөл бүхий засгийн газрын гэрээт оршуулагчтай холбогдох гэж оролджээ. Мөн цогцсуудыг нисэхээс гэр бүл рүү явуулдаг албан хаагчидтай уулзахыг хичээсэн ч санаснаар болсонгүй. Ингэж мухардалд орсны дараа Франклин нууцыг дэлгэхээр шийдэж.

Оршуулгын газарт орсон Франклин Персийн булангийн дайны алба хаагчдын цогцсыг харсан цор ганц сэтгүүлч гэдэг нь тодорхой. Сэтгүүлч байлдааны үеэрх олон үхлийг “сургуулилын үеэрх осол” хэмээн мэдэгдэж байсныг олж мэджээ. Мөн тухайн үед 200 орчим хүн амиа алдсаныг Пентагон 55 гэж мэдээлсэн болохыг тогтоожээ. Франклины “Bay Guardian”-д нийтэлсэн нэг хуудас түүхийн тухай ганц хүн редакцад захидал ирүүлсэн нь цогцсуудыг харснаа аймшигтайгаар дүрсэлснийг шүүмжилсэн байжээ. Түүний бүтээл жил бүр олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн хамгийн шилдэг нийтлэлийг шалгаруулдаг “Project Censored Awards”-т хоёрдугаар байрт шалгарсан юм.

Сан Францискогийн долоо хоног тутмын сонин “Bay Guardian”-ны зохион байгуулалтын редактор Крэйг МакЛауглин нууцыг задалсан сурвалжилгаас ихэнхдээ татгалздаг ч Франклины чөлөөт сурвалжилгыг хэвлэхээр шийдсэн байна. Крэйг МакЛауглин олон түмэнд дайн ямар үр дүн авчирч буйг, телевизээр гарах агшин зуурын зураглалаас илүүтэй Америкийн охид, хөвгүүд амиа алдаж буйг харуулах нь редакторын үүрэг гэж бодсон гэжээ.

МакЛауглин “Цэргийн оршуулгын газар хууран мэхэлсэн явдал нь хувь хүнд чиглэн худал хэлсэн хэрэг биш. Энэ хувийн нууцад халдсан хэрэг биш. Харин засгийн газрын агентлаг Үндсэн хуулиа баримталж чадаагүйд чиглэсэн” хэмээн ярьжээ. МакЛауглин Франклины ажлыг ногоон гэрлээр хэвлэхээр болсон нь нууц аргаар бүтээгдсэн ажилд түүний тавьдаг хоёр шаардлагыг хангасан байж<sup>7</sup>. Эдгээр нь:

- Түүхийг сурвалжлах үүнээс өөр арга (хуурч мэхлэх) байгаагүй.
- Түүх дэх мэдээлэл олон нийтэд хандах бодлогын үр дүнг өгүүлэх тул улс төрийн хувьд уншигчдад амин чухал байсан.

**М**эдээлэлд нэвтрэхийн тулд хуурч мэхлэх нь үргэлж ёс зүйн асуудлыг дагуулж байдаг. Учир нь сэтгүүл зүйн үндсэн зарчим нь үнэнийг өгүүлэх бөгөөд сэтгүүлчээс мэдээлэл цуглуулах, сурвалжлах, түгээхдээ шударга байхыг шаарддаг. Олон нийтэд чухал шаардлагатай үйл явдлын талаар мэдээлэх ганц сонголт нь өөрийгөө худал танилцуулах эсвэл хуурч мэхлэх аргыг ашиглах тохиолдол тун ховор. Крэйг МакЛауглины хоёр шаардлага нь дээрх аргыг ашиглах нь тохиромжтой эсэхийг тодорхойлох процессын үндэс болно.

Үүн дээр нэмэх бас нэг чухал шалгуур бий. Хэрвээ сэтгүүлч хуурамч аргаар мэдээлэл цуглуулсан бол энэ тухайгаа тухайн нийтлэлд олон нийтэд тодорхой мэдэгдэнэ. “Bay Guardian” ч мөн энэ жишгээр Франклиныг сурвалжилгадаа нууц арга ашигласнаа дэлгэхийг шаардаж ёсоор болгожээ. Сэтгүүлчдийг нягт нямбай байхыг өндөр түвшинд шаардаж буй нь олон нийтэд тийм зарчмаар хандах ёстойг сануулж буй хэрэг.

Сэтгүүлчид өөрийгөө худал танилцуулах, нууц микрофон камер ашиглах эсвэл хэн нэгнийг хуурч мэхлэх аль нь байсан ч хамаагүй мэдээлэл цуглуулахдаа шударга бус арга ашигласан гэдгээ хүлээн зөвшөөрөх ёстой. Мөн яагаад ийм зүйл хийснээ тайлбарлах ёстой.

Жонатан Франклины хэргийн тухайн Доверийн Агаарын хүчний баазад оршуулгын ажилтны дүр эсгэхээр шийдсэн нь олон нийтийн ашиг сонирхолд үйлчилсэн хийгээд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хяналтын үүргээ биелүүлснээр тэнцвэржих болно. Түүнчлэн Франклинд өөрийгөө худал танилцуулж мэдээлэл цуглуулахаар өөр ямар ч арга байгаагүйг дахин дурдъя.

**З**аль мэх, төөрөгдүүлэлт, худал ташаа арга ашигласан Монголын сэтгүүл зүйн алдартай кэйс бол “Mongol HD” телевизийн “МакДоналдс сүлжээ ресторан Монголд нээгдэнэ” тухай юм. 2013 оны өвөл Байгуулагдаад удаагүй “Монгол HD” телевиз 2013 оны өвөл “Макдоналдс Монголд” гарчигтайгаар дэлхийн том сүлжээ Улаанбаатарт үүдээ нээх гэж буй тухай хуурамч мэдээллийг өдөр тутмын томоохон хэвлэлүүдэд нийтлүүлэхээр хүргүүлсэн юм. “Өнөөдөр”, “Өдрийн сонин”, “Зууны мэдээ” сонин; news.mn, gogo.mn, olloo.mn сайт; TV5, Eagle, MNB телевиз

гээд Монголын нэр хүндтэй томоохон хэвлэлүүд “Макдоналдс Монголд” төлбөртэй, хуурамч мэдээг шалгаж баталгаажуулалгүйгээр нийтэлсэн<sup>8</sup> байна. Маргааш нь хэргийг санаачлагч “Монгол HD” телевиз энэ талаар мэдээ бэлтгэж Монголын олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн үнэн бодит байдалд хариуцлагатай хандах нь ямар сул байгааг хатуу шүүмжилжээ.

Энэ кэйс Монголын сэтгүүл зүйн салбарт багагүй маргаан дагуулсан. Дараах өдрүүдэд хуурамч мэдээллийг нийтэлсэн хэвлэлүүд мэдэгдэл гаргаж, төлбөртэй мэдээг маркетингийн алба хариуцаад шууд хэвлэдэг тул сэтгүүлчдэд нягтлах, шалгах шаардлага үүсээгүй хэмээн тайлбарласан байв. Мөн тэдгээр хэвлэлүүд сэтгүүл зүй судлаачдыг урьж, мэдээ төлбөртэй байж болох эсэх талаар хүртэл хэлэлцүүлэг өрнүүлж амжсан юм.

Шинэхэн байгуулагдсан “Монгол HD” телевиз энэхүү туршилтаа Монголын сэтгүүл зүй үнэн бодит байдалд хэр хариуцлагатай ханддагийг тандах зорилгоор хийсэн гэж тайлбарласан юм. Энэхүү хэрэг сэтгүүл зүйн салбарынханд маркетингийн контент ч бай, баннер сурталчилгаа ч танай хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэгдэж байгаа мэдээлэл бүрийн үнэн бодит байдлыг нягтлан баталгаажуулж; бусад хэлтэстэйгээ уялдаа холбоотой хамтран ажиллах ёстойг хатуу ойлгуулсан гавьяатай. Мөн “Монгол HD” телевиз мэдээллийн хөтөлбөрийнхөө эхлэл, төгсгөлд хэлдэг “Бид хаалтын гэрээ хийдэггүй” уриагаа олон нийтийн анхааралд оруулж чадсан давуу талтай. Учир нь тэд манай телевиз л шударга, бусад нь төлбөртэй контент бол юуг ч хамаагүй нийтэлдэг гэдэг ойлголтыг төрүүлж чаджээ.

Харамсалтай нь далд зорилгоо биелүүлсэн “Монгол HD” телевизийн туршилт олон нийтийн сэтгүүл зүйд итгэх итгэлийг эрс буруулсан нь ойлгомжтой юм. Бидний хэлэлцэж буй “Заль мэх, төөрөгдүүлэлт, худал ташаа арга ашиглахгүй” зарчмын хувьд ч тэд мэргэжлийн ёс зүйн алдаа гаргажээ. Дээр өгүүлсэн худал хуурмаг арга ашигласныг зөвтгөх 5 шалгуураар авч үзвэл эхний гурван шалгуурыг “Монгол HD” телевизийн туршилт давж чадна. Тэд энэ бол ардчиллын үндэс болсон сэтгүүл зүйн салбарын нүүр царайг илчилсэн, олон нийтийн хувьд амин чухал мэдээлэл гээд эхний шалгуурыг давна, үүнийг буруу гэх боломжгүй. Хоёр дахь шалгуурыг хуурамч мэдээ нийлүүлэхээс өөрөөр үүнийг батлах боломжгүй байсан гээд зөвтгөчихнө. Гурав дахь шалгуурыг бид “олон нийтийн төлөөх” зорилгоор, ингэж туршсан гэдгээрээ хангана. Харин “хуурамч аргаар олж авсан мэдээллийг илчилснээр сэргийлэх хор уршиг нь хуурамч аргаар мэдээлэл олж авснаар гарах хор уршгаас харьцангуй илүү их байх үед” гэсэн дөрөв дэх шалгуурыг хэзээ ч хангаж чадахгүй. Харин ч эсрэгээрээ итгэлцэл дээр тогтдог сэтгүүл зүйн салбарын итгэлийг бууруулснаараа илүү хор уршиг тарьсан хэрэг. Үүнийг “тогоо руугаа нулимахгүй” гэдэг ёс суртахуунгүй үзлээс салгаж авч үзэх хэрэгтэй. Мөн “холбогдсон сэтгүүлчид ёс зүйн шийдвэр гаргахдаа албан ёсны, хамтын, хүлээн зөвшөөрч болох хэлэлцүүлгийг зохион байгуулж, үүндээ хуурч мэхэлснээс үүдэн гарах урт болон богино хугацааны үр нөлөө зэргийг багтаасан олон асуудлыг хэлэлцэнэ” гэдэг шалгуурыг мөн л хангаж чадахгүй юм. Учир нь тэд Монголын хэвлэлүүд хуурамч мэдээг нийтэлсэн тухай

мэдээндээ энэ шаардлагын талаар дурдаагүй.

Мэдээллийн байгууллага болон хувь сэтгүүлчид хуурч мэхлэх аргыг ашиглах эсэхээ шийдэхдээ үйлдлийнхээ богино болон урт хугацааны үр нөлөөг авч үзэх ёстой. Хуурч мэхэлж байж чухал ач холбогдолтой мэдээлэлд нэвтэрч, эрх баригчдыг шударга байхыг шаардаж болно. Гэвч хуурч мэхлэх нь урт хугацаанд үнэн, итгэлцэл дээр тогтдог сэтгүүл зүйн мөн чанарт заналхийлж болзошгүйг мартаж болохгүй.

**Х**уурч мэхлэх асуудал нь хувь сэтгүүлчийн ур чадвар хийгээд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн санал нэгтэйгээр ёс зүйтэй шийдвэр гаргах соёлыг тодорхойлдог. Тиймээс “заль мэх, төөрөгдүүлэлт, худал ташаа аргыг ашиглахгүй” тухай олон улсын хэвлэлүүдийн ёс зүйн кодуудад хэрхэн тусгасныг түүвэрлэн хүргэе.

- “San Jose Mercury News” сонин: Онцгой нөхцөл байдалд сэтгүүлчид, зурагчид мэдээллийн эх сурвалжид өөрийгөө худал танилцуулахыг зөвшөөрнө. Гэвч ингэх шаардлагагүй нөхцөл байдал тохиолдож болно. Зөвхөн ерөнхий редактор энэ аргыг ашиглах зөвшөөрлийг олгоно.
- “Philadelphia Inquirer” корпорац: Олон нийттэй харилцах бидний харилцаанд итгэлцэл чухал учир дүрд тоглох хориотой.
- “The Denver Post” сонин: Бид бүх ажлаа шударгаар хийх ёстой. Бүх нөхцөл байдалд өөрсдийгөө үнэн зөвөөр, тодорхой танилцуулна. Хэрвээ амин чухал мэдээлэл олоход хуурч мэхлэх арга ашиглах шаардлага тулгарвал редактор эсвэл зохион байгуулалт болон мэдээний редакторын зөвшөөрлийг заавал

авна. Тэрхүү мэдээлэл олон нийтийн ашиг сонирхолд ихээхэн нөлөөтэй бөгөөд түүнийг олж авах өөр арга шавхагдсан үед л ашиглана.

— “Detroit Free Press” сонин: Бид худал хэлэхгүй. Бид өөрсдийгөө болон мэдээлэл авч буй зорилгоо худал мэдэгдэхгүй. Бид дуурайлган үйлдвэрлэхгүй. Бид бусдын бүтээлээс хулгайлахгүй. Бид уншигчдыг төөрөгдүүлэх зорилгоор зургийг засварлахгүй. Бид мэдээллийг санаатайгаар гажуудуулахгүй.

— “The Virginian-Pilot” (Norfolk, Virginia) сонин: Сэтгүүлчид, зурагчид үйл явдлыг сурвалжлахдаа өөрийгөө бүрэн дүүрэн танилцуулна. Зарим тохиолдолд үүнийг шүүх шаардлагатай. Тодорхой мэдээний үйл явдал дээр өөрийгөө нээлттэй танилцуулах нь шударгаар сурвалжлахад саад болж болзошгүй. Гэхдээ сэтгүүлч, редактор, гэрэл зурагчид өөрсдийгөө танилцуулахыг хүссэн үедээ худал хэлж, хуурч болохгүй. Сэтгүүлчийг хууль сахиулах, эрүүл мэнд, цэргийн салбарынхны дүрд тоглохыг хориглоно. Энэхүү хориг зөвхөн эдгээр салбараар хязгаарлагдахгүй.

— “The New York Times” сонин: Таймсын сэтгүүлчид түүхийг сурвалжлахдаа өөрсдийгөө худал танилцуулахыг эрмэлзэхгүй. Зарим тохиолдолд өөрсдийгөө тодорхойлох тал дээр чимээгүй байж дүр эсгэхийг хэлтсийн дарга, редактор нарын хамтын шийдвэрээр зөвшөөрнө.

### Эшлэл

<sup>1</sup> <https://accountablejournalism.org/ethics-codes/international>

<sup>2</sup> Esteban Ortiz-Ospina (2016) - "Trust". Published online at OurWorldInData.org.

Retrieved from:

'<https://ourworldindata.org/trust>' [Online Resource]

<sup>3</sup> [http://www.bbc.co.uk/ethics/lying/lying\\_1.shtml](http://www.bbc.co.uk/ethics/lying/lying_1.shtml)

<sup>4</sup> Мөн тэнд

<sup>5</sup> <https://www.poynter.org/uncategorized/2125/abc-and-food-lion-the-ethics-questions/>

<sup>6</sup> <http://ethics.iit.edu/eelibrary/node/8204>

<sup>7</sup> <https://ethicscasestudies.mediaschool.indiana.edu/cases/getting-the-story/using-deceit-to-get-the-truth.html>

<sup>8</sup> <https://ikon.mn/n/12up>

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. М.Зулькафиль. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд: Боть-10: Сэтгүүлчийн хөдөлмөр: Ёс зүй, хариуцлага, үнэлэмж. УБ. 2017.
2. Ч. Чойсамба. Сэтгүүлчийн ёс зүйн алдаа. УБ. 2014.
3. Д.Тунгалаг. Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй. УБ. 2007.
4. Ч. Чойсамба. Ёс зүйн тухай өгүүллэгүүд. УБ. 2016.
5. [www.accountablejournalism.org](http://www.accountablejournalism.org)
6. [www.ourworlddata.org](http://www.ourworlddata.org)
7. [www.bbc.co.uk/ethics](http://www.bbc.co.uk/ethics)
8. [www.ethics.iit.edu](http://www.ethics.iit.edu)
9. [www.ethicscasestudies.mediaschool.indiana.edu](http://www.ethicscasestudies.mediaschool.indiana.edu)
10. [www.ikon.mn](http://www.ikon.mn)

### Summary

In this study, the author explains one of the basic principles of journalistic ethics: "Do not use deception, misleading, or misrepresentation." The article explains this principle of professional ethics from a theoretical and practical point of view, highlighting five criteria for justifying a false approach to journalism. According to these criteria, the cases of "ABC News and the Food lion", "Masquerading of freelance journalist Jonathan Franklin", and "McDonald's in Mongolia" were discussed, followed by other professional newsrooms' ethical principles reflected deception.